## Удирдах ажилтнуудын 09 дүгээр сарын 26-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт

2022 оны 10 дугаар сарын 03

<table>
<tr><th>№</th><th>Өгөгдсөн үүрэг, даалгавар</th><th>Хэрэгжүүлэх хугацаа</th><th>Хэрэгжүүлэх байгууллага</th><th>Биелэлт</th><th>Хувь</th></tr>
<tr><td>1.</td><td>10 дугаар сард Аймгийн Засаг дарга, орлогч дарга нарын оролцох үйл ажиллагааны сарын мэдээгээ ТЗУХ-т ирүүлэх</td><td>10 дугаар сарын 03</td><td>Бүх байгууллага</td><td>Аймгийн Засаг дарга, орлогч даргын 10 дугаар сард оролцох үйл ажиллагааны мэдээллийг нийт 35 байгууллага ирүүлсэн байна.<br>Үүнээс аймгийн Засаг дарга, орлогч дарга нар оролцох 5 үйл ажиллагаа байна. Үүнд:<br>-Боловсрол, шинжлэх ухааны газраас “Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь баярын өдөр”-ийн үйл ажиллагаа 10 дугаар сарын 07-ны өдөр<br>-Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Дотоод аудитын хорооны хурал” 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр<br>-Талын Илч ОНӨААТҮГазраас “Хэрэглэгчээ сонсъё” нээлттэй хаалганы өдөрлөг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр<br>-Биеийн тамир спортын газраас “Хамтдаа хөгжье” уулзалт хэлэлцүүлэг нөхөрсөг тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд<br>“Жудо бөх”-ийн нэрэмжит нээлттэй тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр</td><td>100</td></tr>
<tr><td>2.</td><td>“Нэр өрх-Нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд “Ажил хийх гоё” өдөрлөгт хариуцсан албан хаагч,<br>-өрхийн<br>-төлөөллийг оролцуулах</td><td>09 дүгээр сарын 26</td><td>Бүх байгууллага</td><td>“Ажил хийх гоё” хөдөлмөрийн өдөрлөгийг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж “Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээнд хамрагддаг нийт оролцох байгууллагын 53.1 хувь, 32.7 хувь буюу 34 байгууллага 51 өрхөөс төлөөлөн 61 иргэн оролцсон.<br>“Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээнд хамрагдсан өрхүүдийг өдөрлөгт оролцсон байдлыг сумдаар задалбал:
<table>
<tr><th>№</th><th>Сумдын нэр</th><th>Оролцуулбал зохих тоо</th><th>Оролцсон тоо</th><th>Хувь</th></tr>
<tr><td>1.</td><td>Сүмбэр сум</td><td>Байгууллага-48<br>Өрх-80</td><td>Байгууллага-23<br>Өрх-31</td><td>47.8<br>38.8</td></tr>
<tr><td>2.</td><td>Шивээговь сум</td><td>Байгууллага-9<br>Өрх-48</td><td>Байгууллага-4<br>Өрх-7</td><td>44.4<br>14.6</td></tr>
<tr><td>3.</td><td>Баянтал сум</td><td>Байгууллага-7<br>Өрх-28</td><td>Байгууллага-<br>Өрх-13</td><td>100<br>46.4</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>Байгууллага-64<br>Өрх-156</td><td>Байгууллага-34<br>Өрх-51</td><td>53.1<br>32.7</td></tr>
</table>
Өдөрлөгт “Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээнд хамрагдсан өрхийн төлөөлөл болон ажил хайгч иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа авдаг өрхийн төлөөлөл зэрэг 150 гаруй иргэн оролцсон байна.</td><td>42.9</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Оторчдын хөдөлгөөнд хяналт тавих, отор нүүдлийн хязгаарласан шийдвэр гарган мөрлүүлэх | 10 дугаар сарын 03 | ОБГ, МЭГ, ЦХ, МХГ, Сумдын Засаг дарга нар | Отрын хөдөлгөөнд хяналт тавих ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:<br>**Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар:** Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/278 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УБТЗ-ын Чойр өртөөнөөс бусад нүхэн гарцуудыг хаах тухай албан бичиг хүргүүлсэн. Мөн 4 дүгээр багийн нутагт Өмнөговь, Дорноговь, Дундговь, Хэнтий аймаг руу дайран өнгөрч байсан адуу, бог, малтай малчдыг аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран шалгаж өнгөрүүлсэн. 5, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт одоогоор орж ирсэн отор, нүүдэл байхгүй байна.<br>**Онцгой байдлын газар:** Отрын бүсэд орох, дамжин өнгөрөх маршрут тогтоох аймгийн Засаг даргын захирамжийн төсөлтэй танилцаж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлсэн байна.<br>**Мэргэжлийн хяналтын газар:** 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн хэлтэс, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газартай хамтарч Сүмбэр сумын 4 дүгээр багийн хүрийн ногооны зүүн талд буусан 180 адуу, 33 үхэр, 2120 гаруй толгой бог малтай Өмнөговь аймгийн Номхон сумын 1 дүгээр багийн 2 малчин өрхийг нүүлгэж Дундговь аймгийн Цагаандэлгэр сумруу гаргаж, тухай байрласан газар болон тухайн малчин өрхийн техник хэрэгслийг мал эмнэлгийн газраар халдваргүйтгэл хийлгэсэн байна. | **30** |
| **Нийт дүн** | | | | | **57.6** |

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС